



МОНГОЛ УЛСЫН
ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1998 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 235

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

ТУШААХ НЬ:

1. Батнасангийн Сүхээг Драммын найруулагч мэргэжлээр ОХУ-ын Москва хотын Театр урлагийн академид, Дамдиндоржийн Мэндсайханыг урлагийн менежмент мэргэжлээр, Гончигийн Ариунболдыг Түүх-Архивын мэргэжлээр, Москва хотын Нийгмийн ухааны боловсролын их сургуульд, Балдангийн Сэлэнгийг Эрхүү хотын Анагаах ухааны их сургуульд дотрын эмчийн мэргэжлээр ординатурт 1998/1999 оны хичээлийн жилээс эхлэн 2 жилийн хугацаагаар тус тус суралцуулсугай.

2. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, аспирантур, докторантурт суралцагсадны зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагсадтай гэрээ байгуулж холбогдох төлбөр тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/-д, энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавихыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Алтангэрэл/-д тус тус даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ч.САЙХАНБИЛЭГ

Улаанбаатар хот
21 / 8